

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл (P 159215)

Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл (P174116)

Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ХХҮЕГ-т үйл ажиллагааны дэмжлэг үзүүлэх дотоодын зөвлөхийн

АЖЛЫН ДААЛГАВАР

Үндэслэл

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ) Дэлхийн банкны санхүүжилтээр “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл” болон “Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл”-үүдийг хэрэгжүүлж байна. Төслүүд үндсэн 4 бүрэлдэхүүн хэсэгтэй. Бүрэлдэхүүн хэсэг 1 хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг үйлчлүүлэгч төвтэй болгон хөгжүүлэхэд чиглэгдэнэ. Бүрэлдэхүүн хэсэг 2 хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй хөтөлбөрүүдийг бэхжүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ. Бүрэлдэхүүн хэсэг 3 хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн цар хүрээ, чанар, хүртээмжийг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ. Бүрэлдэхүүн хэсэг 4 КОВИД-19 цар тахлын үед зохих шалгуур хангасан ажиллагчдад түр хугацааны хөнгөлөлт үзүүлэх зорилготой.

Төслийн бүрэлдэхүүн хэсэг 2 нь Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөлийн 2020 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн 02 тоот тогтоолоор батлагдсан “Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөр” (ХЗЗДТХ)-ийн хүрээнд хэрэгжих 1) Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээ 2) Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих орон нутгийн санаачилгын төсөл гэсэн 2 үндсэн үйл ажиллагаанаас бүрдэх ба 2021 оны 2 дугаар сарын 09-ний #03 тоот тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан. ХЗЗДТХ-ийг хэрэгжүүлэх үндсэн зааварчилгааг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн А/177, А/178 тоот тушаалаар баталсан.

Эдийн засгийг дэмжих Засгийн газрын багц арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх хүсэлтийн дагуу төслийн дараагийн үе шат болох “Онцгой байдлын үеийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл” (MERESP, 2020-2023)-ийг эхлүүлээд байгаа бөгөөд уг төслийн хүрээнд бичил бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх юм. Үүний зэрэгцээ хөдөлмөрийн зах зээл дээр эрэлттэй байгаа ур чадваруудыг олгох шинэлэг хөтөлбөрийг турших боломжийг ХНХЯ-нд олгох зорилгоор “Ур чадварын шинэлэг хөтөлбөр”-ийг төслийн бүрэлдэхүүнд нэмж оруулсан. Төслийн бүтцэд өөрчлөлт орсонтой холбоотойгоор ХЗЗДТХ-ийг шинэчлэн боловсруулж, батлуулах юм. ХЗЗДТХ-ийг хэрэгжүүлэхэд ХНХЯ, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний Ерөнхий газар (ХХҮЕГ) болон аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсийн ажилтнуудад чадавх бэхжүүлэх уулзалт, сургалт зохион байгуулахаар төлөвлөж байна.

ХХҮЕГ нь ХЗЗДТХ-ийг хариуцан хэрэгжүүлэх бөгөөд үйл ажиллагаанууд (Ур чадварын шинэлэг хөтөлбөрөөс бусад) Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан (ХЭДС)-гаар дамжин хэрэгжинэ. Хэдий тийм ч ажлын ачааллын улмаас ХХҮЕГ-т ХЗЗДТХ-ийг хэрэгжүүлэх, хяналт мониторинг хийхэд шаардлагатай чадавх, хүний нөөц хангалтгүй байна. ХХҮЕГ-т хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ, төсөл хөтөлбөрүүдийг зохицуулах, хяналт тавих үүрэг бүхий 2 ажилтан байдгаас 1 нь ажилд зуучлах үйлчилгээний хэрэгжилтийг зохицуулах, хянах үүрэг гүйцэтгэдэг байна. Тэдгээр ажилтнууд Хөдөлмөр эрхлэлтийн үндсэн буюу ХЭДС-аар дамжин хэрэгждэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд ачаалалтай ажилладаг.

Тиймд ХЗЗДТХ-ийг хэрэгжүүлэх ХХҮЕГ-т үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхийн тулд ХНХЯ нь ХХҮЕГ болон төсөл хэрэгжүүлэх нэгжийн байранд байрлаж ажиллах дотоодын зөвлөхийг ажиллуулахаар төлөвлөж байна.

<p>Зөвлөхийн гүйцэтгэх ажлын цар хүрээ</p>	<p>Энэхүү зөвлөх үйлчилгээний зорилго нь ХХҮЕГ-т ХХҮГ/Х-үүдээр дамжуулан ХЗЗДТХ-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг үзүүлэх ба хэрэгжүүлэгч байгууллагуудын хоорондын харилцаа холбоо, зохицуулалтыг хангаж ажиллахад оршино.</p> <p>Зөвлөх нь Төсөл хэрэгжүүлэх нэгжийн заавар, чиглэл, зохицуулалтын хүрээнд ХХҮЕГ-ын холбогдох ажилтнуудтай нягт хамтран дараах ажлуудыг гүйцэтгэнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1) ХХҮГ/Х-үүд, ХХҮЕГ, ХНХЯ, ТХН гэх мэт ХЗЗДТХ болон Ур чадвар олгох шинэлэг хөтөлбөр (УЧОШХ)-ийг хэрэгжүүлэгч гол байгууллагуудын хоорондын харилцаа холбоо, зохицуулалтыг хангаж ажиллах; 2) ХХҮГ/Х-ийн ажилтнуудад тодорхой сэдэв, асуудлаар чадавч бэхжүүлэх сургалт, цахим уулзалт, мэдээлэл солилцох арга хэмжээг тогтмол зохион байгуулах, зохицуулахад дэмжлэг үзүүлэх; 3) ХЗЗДТХ болон УЧОШХ-ийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаанууд болон тэдгээрийн үр дүнд бий болсон ололт амжилт, сайн туршлагауудыг сурталчлах, олон нийтэд таниулахад чиглэсэн материал бэлтгэж, түгээхэд дэмжлэг үзүүлэх; 4) ХЗЗДТХ-ийг хэрэгжүүлэх болон тайлагнахад ХХЕГ/Х-үүдэд дэмжлэг үзүүлж, удирдамж чиглэлээр хангах; 5) ХХҮГ/Х-үүдээс бичил бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээнд хамрагдсан үр шим хүртэгчдийн дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулж, нэгтгэж, дүн шинжилгээ хийх; 6) Шаардлагатай үед холбогдох загвар, маягт болон бусад баримт бичгүүдийг боловсруулах болон сайжруулахад ХХҮЕГ-т дэмжлэг үзүүлэх; 7) ХЗЗДТХ болон УЧОШХ-ийг хэрэгжүүлэх явцад гарсан үр дүн, тулгарсан бэрхшээл, сургамж, ололт амжилтыг онцлон харуулсан товч тайлан бэлтгэх; 8) ТХН-ийн зохицуулагчид хянуулж, зөвшилцсөн сар тутмын төлөвлөгөөнд тусгасны дагуу ХХҮЕГ-т дэмжлэг үзүүлэх бусад шаардлагатай үйл ажиллагааг хэрэгжүүлэх.
---	--

Зөвлөхөд тавигдах шаардлага	<p>Зөвлөх дараах мэдлэг, чадварыг эзэмшсэн байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Хөдөлмөр, нийгмийн хамгаалал болон бусад холбогдох чиглэлээр бакалавраас доошгүй зэрэгтэй; • Хөдөлмөрийн салбарт болон хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр дор хаяж 5 жилийн ажлын туршлагатай байх; • Хөдөлмөр эрхлэлтийн бодлого, дүрэм журмын талаар мэдлэг, ойлголттой байх; • Компьютерын хэрэглээний программ дээр ажиллах чадвартай байх MS Office (Word, Excel, PowerPoint etc.); • Харилцааны өндөр ур чадвар байх; • Ганцаарчлан болон багаар хамран ажиллах чадвартай байх; • Зохион байгуулах болон ажлын ачаалал даах чадвартай байх.
Явцын тайлан, үр дүнг хянах	<p>Зөвлөх нь ХЭДТ-ийн төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН)-ийн хяналт дор дээрх ажлуудыг гүйцэтгэнэ. Зөвлөхийн ажлын гүйцэтгэлийг дараах шалгуур үзүүлэлтүүдээр үнэлнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> -Ажлын даалгаварт тусгагдсан ажлуудыг бүрэн гүйцэтгэсэн байдал; -Нийлүүлэх үр дүнг заасан хугацаанд гүйцэтгэсэн байдал; -Гүйцэтгэсэн ажлын чанар.
Ажлын байр	<ul style="list-style-type: none"> • Зөвлөх ТХН-ийн өрөө, тоног төхөөрөмжийг ашиглана. • Зарим тохиолдолд ХХҮЕГ -ын оффист ажиллах боломжтой.
Гэрээний хугацаа	<ul style="list-style-type: none"> • Зөвлөх 2022 оны 01 дүгээр сарын 01-ээс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал 12 сарын хугацаатай бүтэн цагаар ажиллана.
Хэрэгжүүлэх ажил	<p>Зөвлөх дараах бүтээгдэхүүнүүдийг нийлүүлнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • ТХН-тэй зөвшилцөн боловсруулсан сар тутмын үйл ажиллагааны төлөвлөгөө- тухайн сарын 5-ны өдрийн дотор; • ТХН-ийн зохицуулагчийн өгсөн ажил, үүргийн гүйцэтгэлийн сар тутмын тайлан (гаргасан, баримт бичиг, материалыг тайланд хавсаргана)- дараа сарын 1-ний өдрийн дотор; • Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээнд хамрагдсан үр шим хүртэгчдийн тоо мэдээг нэгтгэж, дүн шинжилгээ хийсэн тайлан- 2 сар тутамд; • Бусад нэмэлт ажлууд.
Тайлагналт	<p>Зөвлөх ТХН-ийн зохицуулагчид тайлагнана.</p>